

ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

№	Хүлээсэн үүрэг	Биелэлт	Биелэлтийн хувь
3.1	Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, шүүхийн маргаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийг шүүхэд төлөөлж гарсан үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө хариуцна.	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох тухай асуудал гараагүй болно.	100
3.2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 1 бүлэг, 1 зорилт 60 хувьтай, Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө 1 бүлэг 2 арга хэмжээний хэрэгжилт 80 хувьтай, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2 бүлэг 5 арга хэмжээний биелэлт 86 хувьтай, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 7 бүлэг 12 арга хэмжээний биелэлт 86 хувьтай, Нийслэлийн Засаг даргын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 7 бүлэг 12 арга хэмжээний биелэлт 90,8 хувьтай тус тус биелсэн байна.	80
3.3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	1.Газрын даргын 2023 оны А/63 дугаар тушаалаар "Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд тавигдах нийтлэг шаардлага"-ыг батлан, төрийн байгууллагын зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгийг илэрхийлсэн баталгааны хуудсыг гарын үсгээр баталгаажуулан авч хэвшсэн бөгөөд зөрчил үүссэн тухай мэдэгдэл гараагүй болно. 2.Газрын даргын 2023 оны А26 дугаар тушаалаар өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Үндсэн	100

		хөрөнгө, бараа материалын орлого, зарлагын бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын хэсгийг хагас жилээр газрын даргын А/37 дугаар тушаалаар, жилийн эцэст А/79 дүгээр тушаалаар тус тус байгуулсан бөгөөд зөрчил дутагдал илрээгүй байна.	
3.4	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.	<p>1.Төрийн албаны хууль дээдлэх зарчмыг хангах төр, иргэний өмнө хүлээсэн үүргийг биелүүлэн Төрийн албаны зөвлөлийн 43 дугаар тэмдэглэлийн дагуу төрийн албаны тусгай шалгалтад хамрагдаагүй нэгжийн дарга-3, мэргэжилтэн-3, нийт 6 албан хаагчийг чөлөөлж, хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>2.Соёлын сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлснээр 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор 3 нэгжийн дарга, 9 мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хянуулж, баталгаажуулах эрх авч, тогтоолын дагуу Газрын даргын 2023 оны А/51 дүгээр тушаалаар нэгжийн дарга-3, мэргэжилтэн-10, төрийн үйлчилгээний ажилтны-1 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан.</p> <p>3.Шинэчлэн батлуулсан Албан тушаалын тодорхойлолтын дагуу Нийслэл дэх төрийн албаны зөвлөлд 8 сул орон тооны захиалга хүргүүлж тусгай шалгалт зарлагдсанаар 4 орон тоонд сонгон шалгаруулалтаар албан хаагчид томилогдсон.</p>	100
3.5	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.	<p>Онлайн бизнес төвөөр дамжуулан дараах зөвшөөрлийг олгож байна. Үүнд:</p> <p>1.Соёл, урлагийн (дуу хөгжим, бүжиг, драм, кино, загвар, хөтлөгч, жүжигчин, тайзны яриа, илтгэх урлаг, уран зураг, фото зураг, төрөл бүрийн хатгамал, нүүр будаг, хувиргалт) сургалтын газрын үйл ажиллагаа,</p> <p>2.Дэлгэцийн болон дүрс бичлэгийн бүх төрлийн кино үзвэрийн газруудын үйл ажиллагаа,</p>	100



		<p>3.Соёлын төв, үзвэр үйлчилгээний газрын зөвшөөрлийг олгоход хамтран оролцож байна. Арга зүйн 3 удаагийн сургалтыг байгууллагын хүсэлтээр зохион байгуулсан.</p>	
<p>3.6</p>	<p>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.</p>	<p>Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 2023 оны 01 сарын 24-ний өдөр, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/64 дугаар тушаалаар шинэчлэн тус тус батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Үүнд:</p> <p>Албан хаагчийн сургалт, ажлын байрны ур чадварын сургалт, хувь хүний хөгжлийн сургалтаар 3 ангилан 20 удаагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөж нийт 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 522 албан хаагч хамрагдсан байна . Үүнд:</p> <p>1.“Удирдлагын академи”-ийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 1, дунд хугацааны давтан сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж төгссөн.</p> <p>2.Ажлын байрны ур чадварын хууль эрх зүй авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, төрийн албаны тухай хуулийн шинэчлэл, төрийн албан хаагчийн ёс зүй, эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн 5 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 72 албан хаагч бодлого төлөвлөлт захиргааны байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд нийт 15 сургалтад давхардсан тоогоор 46 албан хаагч, төрийн архив, албан хэрэг хөтлөлт, цахим системийн 5 сургалтад 20 албан хаагч, нийт 25 сургалтад 138 албан хаагч хамрагдсан байна.</p> <p>3.Хувь хүний хөгжлийн сургалтын төлөвлөлтийн хүрээнд Нийслэлийн харьяа 11 соёл, урлагийн байгууллагын 380 албан хаагчид болон дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан “Төрийн бүтээмж ба бүтээлч албан хаагч” сэдэвт чадавхжуулах</p>	<p>100</p>

		сургалтыг Соёлын яам, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан.	
3.7	Аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гарган арга хэмжээг авна.	Байгууллагын хэмжээнд нийт 18 өргөдөл гомдол ирснийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажилласан. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд албан бичгээр хариу өгсөн 6, цахимаар хариу өгсөн 4, утсаар хариу өгсөн 7, иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн 1 байна. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хандалтаар нь авч, үзвэл: Урлаг соёлын арга хэмжээний тухай 4 (22.3%) ажилд шилжих, дэвшин ажиллах тухай 2(11.2%), ажлаас чөлөөлөгдөх тухай 2 (11.2), нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тухай 1 ( 5.6 %) хүрээлэн буй орчны тухай 1 буюу (5.6%) хөшөө, түүх соёлын дурсгалт зүйлийн тухай 1 буюу (5.6%) боловсролын салбарын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) цалинтай чөлөө хүсэх тухай 1 (5.6%) ээлжийн амралтын тухай 1 (5.6%) 10 зар сурталчилгаа, мэдээллийн самбарын тухай (5.6%) согтууруулах ундааны зөвшөөрөл, худалдаа, үйлчилгээний тухай (5.6%) нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) байна.	100
3.8	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хурал 32 удаа хуралдаж тухай бүрд өгсөн үүрэг даалгаврын төлөвлөгөө боловсруулан батлуулж биелэлтийг тухай бүрд нь цахим программд тайлагнаж, хэрэгжилтийг ханган ажилласан.	100
3.9	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн төвлөрүүлэн захирагч Соёлын сайд С.Номин, Төсвийн ерөнхийлөн захирагч Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазартай 5 зорилтын 47 арга хэмжээг төлөвлөн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Нийт хэрэгжилтийн дундаж 93,8 хувьтай байна.	94
3.10	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил	Нийслэлийн Соёл, урлагийн газар веб хуудас хаагдсан байсныг 2023 оны 5 дугаар сард нээлгэн, мэдээллийг шинэчлэн, баяжуулж, фейсбүүк пейж хуудсаар шинэ	100



	<p>тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор <a href="http://blegal.ulaanbaatar.mn">blegal.ulaanbaatar.mn</a> цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.</p>	<p>мэдээ мэдээллийг түгээн, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллаж, хуудсыг дагагчдын тоо 33600-д хүрсэн.</p>	
3.11	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.</p>	<p>-Нийслэлийн Засаг даргын соёл, урлагийн чиглэлээр иргэдийг хөгжүүлэх зорилтын 2023 онд зохион байгуулах зарим арга хэмжээний жагсаалт А/373, сургалт зохион байгуулах тухай А/374, хөрөнгө гаргах тухай А/163, А/372, А/470, А/471, А/530, А/766, А/661, А/686, А/710, А/1242, А/1250, А/1322, А/1343, А/1361 захирамжуудыг батлуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэн тайланг тухай бүрд нь гарган ажиллаж байна.</p> <p>-Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны өдрийн дотор 3 төрлийн мэдээллийг, тухай бүр оруулах 7 мэдээллийг цаг тухай бүрд нь хоцрогдолгүйгээр оруулж хэвшсэн.</p>	100
3.12	<p>Хууль тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэгдэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол, 2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоол, 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022</p>	<p>-2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоолын дагуу байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн төвлөрүүлэн захирагч Соёлын сайд С.Номин, Төсвийн ерөнхийлөн захирагч Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазартай 5 зорилтын 47 арга хэмжээг төлөвлөн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>1.2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоолын дагуу нэгжийн дарга болон албан</p>	100




<p>оны “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 448 дугаар тогтоол, 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол, 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах” тухай 360 дугаар тогтоол, 2022 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 430 дугаар тогтоол, 2022 оны 487, 488, 490, 491 дүгээр тогтоол, 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолуудыг тус тус хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хагас, бүтэн жилээр үнэлэн урамшууллыг олгосон.</p> <p>2.2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг баримтлан ажилласан.</p> <p>3.2022 оны “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 448 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд тус газар нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг холбогдох яам, агентлагт шилжүүлсэнтэй холбогдуулан Соёлын хяналтын улсын байцаагчийг Газрын даргын Б/01 дүгээр тушаалаар томилсон.</p> <p>4.2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дүүргүүдийн Соёлын төв, соёлын орднуудын орчин нөхцөлтэй танилцах ажлыг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулж, Соёлын дэд сайд Д.Батбаяраар ахлуулсан сайдын ахлах зөвлөх Оюунбилэг, Газрын дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийслэлийн 7 дүүргийн Соёлын орднуудын барилга, байгууламж, орчин нөхцөлтэй газар дээр нь танилцаж, дүүрэг тус бүрд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>5.2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах” тухай 360 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 15 хүний бүтэц орон тоотойгоор ажиллаж байна.</p> <p>6.2022 оны 487, 488, 490, 491 дүгээр тогтоол Газрын даргын 2023 оны А/02 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсан.2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу Газрын даргын Б/25 дугаар тушаал албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож,</p>	
---	--	--

		<p>490 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 06 дугаар сараас эхлэн албан хаагчдад илүү цагийн хөлс олгон ажилласан. 7.2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 206 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 1 бүлэг, 1 зорилт, Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө 1 бүлэг 2 арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр, улирлаар, “Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2 бүлэг 5 арга хэмжээний биелэлт, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 7 бүлэг 12 арга хэмжээний биелэлт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 7 бүлэг 12 арга хэмжээний биелэлтүүдийг улирал бүр хариуцсан хэлтэс, нэгжүүдээс авч нэгтгэн 36 удаа тайлагнаж ажилласан.</p>	
3.13	<p>Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангаж, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцна.</p>	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 01 дүгээр тушаалаар 2023 онд зохион байгуулах бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг баталсан бөгөөд хуваарийн дагуу цэвэрлэгээг хийж тайланг Dispatcher_ub@yahoo.com хаягаар хүргүүлэн ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр “Ердөө 90 минут” их цэвэрлэгээний ажлын удирдамжийн дагуу байгууллагын гаднах орчны 50 м хүртэлх зам, талбайг,</li> <li>2.2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 17 цагаас “Хоггүй шинэлье” бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчид хамрагдаж орчны 50м2 талбайг,</li> <li>3.“Хаврын их цэвэрлэгээ 90 минут” арга хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цагаас Бага тэнгэрийн амны харалдаа хойд талаас баруун тийш 800 метр Туул гол дагуу голын хэсгээр,</li> </ol>	100



		4.“Их дэлхийн цэвэрлэгээний өдөр” арга хэмжээ 2023 оны 09 дүгээр сарын 16-ны Бямба гаригт 10:00 цагаас Дамдинсүрэнгийн гудамжны гүүрнээс Нарны зам хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу, 5.2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 12:00 цагаас Драгоны буудлаас баруун тийш Лабораторийн гэрлэн дохио хүртэл урд талдаа зам талбай	
3.14	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллана.	-	
	Хэрэгжилтийн дундаж хувь		91

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.МӨНХЧУЛУУН

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ХҮНИЙ НӨӨЦ,  
СУРГАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.УНДРАХ